

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НАРЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын 1996 оны хэлэлцээр нь Монгол, Францын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны үндсэн зарчим, зорилтыг тодорхойлсон баримт бичиг болохыг Ерөнхийлөгч нар тэмдэглэв.

Монгол, Францын улс төрийн яриа хэлэлцээг тогтмолжуулах, хоёр орны Гадаад хэргийн яам хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалтыг хоёр талын хамтын ажиллагаа болон олон улсын харилцааны харилцан сонирхсон асуудлуудыг хэлэлцэх, мэдээлэл солилцох суваг болгон үргэлжлүүлэх замаар тогтмол зохион байгуулж байхаар тогтов.

Монгол, Францын худалдаа эдийн засгийн харилцаа болон харилцан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн чухлыг хоёр Ерөнхийлөгч тэмдэглэн, дэд бүтэц, уул уурхайн үйлдвэрлэл, байгаль орчныг хамгаалах, эрүүл мэнд, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарууд нь эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал чиглэл болохыг тодорхойлов.

Монгол Улс нийгэм, эдийн засгийн шилжилтийн үеийг даван туулахад Бүгд Найрамдах Франц Улс буцалтгүй тусламж үзүүлсээр ирсэнд Монголын ард түмэн талархаж байгааг Монгол Улсын Ерөнхийлөгч илэрхийлэв.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар Монгол Улсад ус болон хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ нотлов.

Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг байгуулах, Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах сүлжээг байгуулах зэрэг төсөлд зориулан Францын Засгийн газар хөнгөлөлттэй зээл олгохоо мэдэгдэв.

Монгол, Францын соёл, боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагааг өргөжүүлэх, археологийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Гол мод”-ны судалгааны ажлыг цаашид үргэлжлүүлэх, олдворыг олон нийтэд дэлгэн үзүүлэх зорилгоор Франц Улсад үзэсгэлэн гаргахаар талууд тохиролцов. Хоёр улсын Төрийн тэргүүн нар өөрсдийн ивээл дор Гол мод дахь Хүннүгийн үеийн булшнаас олдсон ховор олдворуудаар Улаанбаатар болон Парис хотноо үзэсгэлэн гаргах боломжийг судлахаар тогтов.

Монгол, Францын өргөжин хөгжиж буй харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх үүднээс айлчлалын үеэр хоёр орны Засгийн газар хооронд Иргэний агаарын тээврийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, Францын Эдийн засаг, санхүү, аж үйлдвэрийн яам хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг, Ус болон хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтын асуудлаар Монгол Улсын Сангийн яам, Францын Эдийн засаг, санхүү, аж үйлдвэрийн яам хоорондын санамж бичиг, Монгол Улсын Шинжлэх ухааны Академи, Францын хөдөө аж ахуйн судалгааны Үндэсний хүрээлэн хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Парисын Худалдаа, аж үйлдвэрийн танхим хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг зэргийг байгуулав.

Монголын залуучуудад Францын их, дээд сургуульд суралцахад олгох Францын Засгийн газрын тэтгэлгийн тоог нэмэгдүүлэхээр талууд тохиров. Их, дээд сургуулийн диплом, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрүүдийг байгуулах боломжийг судлахаар болов.

Ерөнхийлөгч нар олон улсын бодлогын асуудлаар санал солилцож, энэ чиглэлд НҮБ-ын хүрээнд хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэхээр тогтов. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалан хамгаалахад НҮБ-ын үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж байгааг нотлон НҮБ өөрөө үр өгөөжтэй, ил тод, өнөөгийн бодит нөхцөлд зохицон шинэчлэгдэх ач холбогдолтойг тэмдэглэв. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, бүс нутгийн хэмжээнд, ялангуяа Зүүн Хойд Азид хамтын ажиллагаа, яриа хэлэлцээг хөгжүүлэх явдал чухал болох талаар санал нэгдэв.

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс 2006 оны аравдугаар сарын 9-ний өдөр цөмийн туршилт хийснийг Монгол, Франц улсууд буруушааснаа нотлоод НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1718 тогтоолыг биелүүлэхийг Хойд Солонгосын талд уриалав. Талууд Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлаарх зургаан талт яриа хэлэлцээний сүүлийн хуралдаанаар тохирсон тогтолцоог найрсагаар хүлээн авав.

Ази, Европын яриа хэлэлцээний механизм АСЕМ-ын 2006 оны есдүгээр сарын 11-нд болсон Хельсинкийн дээд хэмжээний уулзалтын үеэр Монгол Улсыг элсүүлэхэд Франц Улс Европын түншүүдийнхээ хамт дэмжсэнд талархаж байгаагаа Монгол Улсын Ерөнхийлөгч илэрхийлэв. Европ, Азийн энэ яриа хэлэлцээг 1996 онд эхлүүлэхэд оролцсон

Францын Ерөнхийлөгч энэ яриа хэлэлцээний үйл явцад Монгол Улс элсэн орсонд баяр хүргэв.

Хамгийн ядуу хөгжиж буй орнуудад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийг санхүүжүүлэх шинэ эх үүсвэр олох талаар, тухайлбал нисэх онгоцны билетэд эв санааны нэгдлийн татвар ноогдуулж аюултай халдварт өвчнүүдийг эмчлэх эм, тариа худалдан авахыг санхүүжүүлэх тусгай сан байгуулах зэрэг дэвшүүлсэн Францын талын тодорхой санал санаачлагыг бүрэн дэмжиж байгаагаа Монгол Улсын Ерөнхийлөгч илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНФУ-д хийсэн албан ёсны айлчлал нь хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, соёл, боловсролын салбарт өргөжүүлэн хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлийн нотолгоо болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр, Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Жак Ширак нар ардчиллын нийтлэг үнэт зүйлст тулгуурласан Монгол, Францын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд идэвхтэй хөгжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, энэ хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэхээр тохиров. Монгол, Францын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа нь хүний эрх, ардчилсан зарчмуудыг дээдлэн хөгжүүлэх, олон улсын эрх зүй, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, тогтвортой хөгжил, энх тайвныг хамгаалах, олон улсын тогтвортой байдлыг хадгалах, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийн эсрэг тэмцэх, терроризмтай тэмцэх, байгаль орчин, соёлын олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах зэрэг хоёр орны нийтлэг эрх ашигт тулгуурлан хөгжихийг талууд нотлон тэмдэглэв.